Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл нь 291,678.4 мянган төгрөг болж өмнөх оноос 211,440.0 мянган төгрөгөөр өссөн нь тухайн байгууллагын цалингийн сангаас

193,414.8 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 14,941.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 12,172.8 мянган төгрөг, нормативт зардлаас 10,186.2 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардлаас 11,047.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 42,637.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардлаас 11,352.0 мянган төгрөгийг хэмнэж Засгийн газрын 2022 оны 91 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралт "Хувьсах зардлын дундаж нормативаар төсөв хуваарилах, санхүүжүүлэх аргачлал"-ын 8.7-д "Боловсролын сургалтын байгууллагын жилийн эцсийн дансны үлдэгдлийг дараагийн төсвийн жилд шилжүүлнэ" гэж заасны дагуу төрийн сангийн харилцах дансанд үлдэгдлээр тайлагнагдсан байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 171,809.4 мянган төгрөг болж 51,617.4 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 17,270.5 мянган төгрөгийн бичиг хэргийн материал, 7,832.9 мянган төгрөгийн барилгын засварын материал, 94,891.2 мянган төгрөгийн хүнсний материал, 675.7 мянган төгрөгийн эм боох материал, 37,151.8 мянган төгрөгийн аж ахуйн бараа материалыг орлогоор бүртгэж, 12,748.9 мянган төгрөгийн хандив тусламжаар бараа материал авсан бөгөөд үйл ажиллагаанд 118,948.3 мянган төгрөгийн хөрөнгийг зарцуулсан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 2,521,419.9 мянган төгрөг болж 208,670.6мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 47,819.4 мянган төгрөг, хандив тусламжаар 316,049.6 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө нэмэгдсэн, мөн акталсан хөрөнгө болон үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 2,984,907.7 мянган төгрөг болж 502,783.3 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тус байгууллагын 2024 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 2,031,475.5 мянган төгрөг, орон нутгийн төсвөөс 75,418.8 мянган төгрөг, улсын төсвийн нийт зарлагыг 2,031,475.5 мянган төгрөгөөр, орон нутгийн төсвөөс 75,418.8 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн төслийн саналаас улсын төсөв 2,031,475.5 мянган төгрөг, нийт зардлыг 1,935,890.4 мянган төгрөгөөр буюу 95,585.1 мянган төгрөгөөр илүү баталсан байна. Орон нутгийн төсвийн саналаас 75,418.8 сая төгрөг баталсан.

### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 12 арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,031,475.5 мянган төгрөгийг улсын төсвөөс бүрдүүлсэн байна.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,031,475.5 мянган төгрөгийн санхүүжилт олгож, Орон нутгийн төсвөөс 42,500.0 мянган төгрөгийн санхүүжилт авч, 11,352.0 мянган төгрөгийг буцаан төвлөрүүлсэн байна

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,935,890.4 мянган төгрөг буюу 89.5 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 225,227.0 мянган төгрөг дутуу

зарцуулсан нь эхний үлдэгдэл болон боловсролын ерөнхий газрын менежмэнтийн сургалтын төлбөр, мэдээлэл технологийн төлбөрүүдийг хойшлуулсантай холбоотой , орон нутгийн төсвөөс 32,918.8 мянган төгрөгөөр дутуу санхүүжүүлсэнтэй холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

*/мянган төгрөгөөр/*

| Д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт |
|---|---|---|---|---|---|
| 1 | 80226- Байр ашиглалтын үйлчилгээ | 3,502.0 | 3,502.0 | 0.0 | 100% |
| 2 | 80233- Хүүхэд хамгаалал | 3,714.6 | 3,714.6 | 0 | 100% |
| 3 | 80312- Сургалт семинар | 2,494.3 | 2,494.3 | 0.0 | 100% |
| 4 | 81605- Эрүүл мэндийг дэмжих | 3,316.4 | 3,316.0 | 0.4 | 100% |
| 5 | 81801- Үдийн цай хөтөлбөр | 47,735.4 | 47,735.4 | 0.0 | 100% |
| 6 | 81806-Дотуур байрны хүүхдийн хоол | 278,142.8 | 262,923.9 | 15,219.0 | 103% |
| 7 | 81816- Хүүхдэд ээлтэй сургалтын орчин | 14,092.5 | 14,092.5 | 0.0 | 100% |
| 8 | 81823- Боловсролын багшийн сургалт | 9,967.4 | 6,000.0 | 3,967,4 | 60% |
| 9 | 81834- Боловсролын стандарт сургалт | 1,659,023.2 | 1,455,699.6 | 223,637,2 | 86.6% |
| 10 | 81835-Сургалтын хэвийн үйл ажиллагаа | 48,964.4 | 48,964.4 | 0.0 | 99.7% |
| 11 | 81844- Гүнзгийрүүлсэн болон төрөлжсөн сургалт | - | - | - | 100% |
| 12 | 81848- Сурах бичгийн түрээс | 940.8 | 940.8 | - | 100% |
| 13 | 80111- Төрийн өмчийн байгууллагын тогтмол зардал | 75,418.8 | 63,247.9 | 12,170.9 | 83.8% |
| 14 | 81875-Сургалын нэмэлт хөтөлбөр хэрэгжүүлэх | 3,804.8 | 1,906.9 | 1,897.9 | 100% |
| 15 | 83603-Дээд шатны төсвөөс хуваарилсан | 20,000.0 | 10,000.0 | 10,000.0 | 100% |
| | Дүн | 2,161,117.4 | 1,924,538.3 | 236,579.1 | 89.05 % |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

“Ахмадын тухай хууль”-ийн 14 дүгээр зүйлийн 14,7 дахь заалтын дагуу “Ахмадын сан ” үүсгээгүй байна.

Дотуур байрны хүүхдийн хоол хүнсний материал худалдан авахаар 105,077.4 мянган төгрөгийн ДУАЭЦС/20240302001 дугаартэй нээлттэй тендер шалгаруулалтыг 2 удаа цахимаар зарласан боловч оролцогчгүй амжилтгүй болсон. Гэрээ байгуулан шууд худалдан авалтаар 94,891.2 мянган төгрөгийн материал худалдан авсан.

Төсвөөс 2024 онд зарцуулсан бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил, үйлчилгээний төлбөр, хураамж /210801/ зардалд 940,8 мянган төгрөгийн түрээсийн номын орлого төвлөрүүлсэн.

210901 зардлаас ариутгал цэвэрлэгээний материал худалдан авсан, багшийн хөгжил сургалт, семинарын зардал, багшийн эрүүл мэндийг дэмжих зардал, хүүхэд хамгааллын зардал, аудит бусад үйлчилгээний төлбөр хураамжийн зардалд 47,820.2 мянган төгрөг зарцуулсан

2024 онд батлагдсан орон тоо 56, гүйцэтгэлээрхи орон тоо 56. Орон тоонд өөрчлөлт ороогүй.

**3.5.3 Нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд орлого, зарлагын гүйлгээ байхгүй байна.

**3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн**

Тайлант онд тус байгууллага дээр улсын төсвийн хөрөнгө оруулалтаар мянган 275,090.0 төгрөгийн тоног төхөөрөмж болон тоглоомууд төслийн дагуу бүрэн хийгдэж дууссан

*Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт*

/мянган төгрөгөөр/

| № | Хөтөлбөр | Хэрэгжих хугацаа | Хүрэх үр дүн | Хэрэгжилтийн явц | Зарцуулах төсөв | Зарцуулсан |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | Дархан сум төсөл хөтөлбөр/Бочи/ | 2023.01-2023.12 сар | Сургалтын байгууллагад суралцаж байгаа сурагчдыг тэгш хамруулан сургах | Төсөл хөтөлбөр нь тоглоомууд төслийн дагуу бүрэн хийгдэж дууссан | 10,140.0 | 10,140.0 |
| 2 | Боловсролын ерөнхий газар | 2023.01-2023.12 сар | Сурагчдын автобус | Тээврийн хэрэгсэл | 264,950.0 | 264,950.0 |
| | Дүн | | | | 275,090.0 | 275,090.0 |

***3.5.5 Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл***

2024 оны худалдан авах ажиллагааг урсгал төсвийн хүрээнд хуулийн дагуу хугацаанд нь tender.gov.mn, shilendans.gov.mn сайтуудаар байршуулан нийтэлж, тайланг цахим болон цаасаар хүргүүлж ажилласан байна. tender.gov.mn сайтад 93,878,000 төгрөгийн хүүхдийн хоол хүнсний нээлттэй тендер шалгаруулалтыг тайлагнаж ажилласан байна. Хүүхдийн хоол хүнс худалдан авах нээлттэй тендер шалгаруулалтыг тайлант онд зарласан боловч Тендерт оролцогч ирээгүй учир гэрээт байгууллагуудтай хамтран ажиллах, шууд худалдан авах гэрээгээр 94,891.2 төгрөгийн худалдан авалт хийж ажилласан байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

**4.1 Ерөнхий зүйл**

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар сургуулийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн

үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах, санхүүгийн сахилга батыг дээшлүүлж, төсвийн хөрөнгийг хэмнэлттэй, үр ашигтай зарцуулахтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газартай байгуулсан гэрээний дагуу "Шинжлэн магадлахуй ЭЗШ аудит" ХХК-ийн аудитор Б.Хоролбат гүйцэтгэж, Анхан шатны чанарын хяналтыг аудитын менежер Л.Магсаржалам, гүйцэтгэх захирал С.Оргил нар дараагийн шатны чанарын хяналтыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар сургуулийн 2024 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг "Шинжлэн магадлахуй ЭЗШ" аудит ХХК-д 2025 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 01 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

**4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр үр дүнгийн тайлан дахь нийт зардлын дүнг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлан дахь нийт зардал 1,375,114.1 мянган төгрөгөөс 2 хувиар буюу 27,502.3 мянган төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох *шаардлагагүй* гэж үзсэн.

**4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар сургууль нь ашиглалтын зардлын хэрэглээг хянаж ажилласан байна.

Энэ хуулийн хүрээнд гүйцэтгэлээр санхүүжүүлсэнтэй холбоотойгоор цалингийн сангаас 193,414.8 мянган төгрөг, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлаас 14,941.5 мянган төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 12,172.8 мянган төгрөг, нормативт зардлаас 10,186.2 мянган төгрөг, мэдээлэл технологийн зардлаас 11,047.9 мянган төгрөг, бараа үйлчилгээний бусад зардлаас 42,637.2 мянган төгрөг, бусад урсгал шилжүүлгийн зардлаас 11,352.0 мянган төгрөгийн хэмнэлтийг бий болгон ажилласан байна.

**4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

**4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Дархан-Уул аймгийн Дархан сумын 12-р сургуулийн 2024 онд мэдээлбэл зохих 171 мэдээллийг хуульд заасан хугацаанд бүрэн байршуулсан байгаа тул шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн хүрээнд гарсан алдаа, зөрчилтэй асуудал байхгүй. Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д " Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах" гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

_Шийдвэрлэсэн нь_:

Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.7-д заасны дагуу “Ахмадын сан” байгуулж, Засгийн газрын 2024 оны 243 дугаар тогтоолоор баталсан “Ахмадын сан байгуулан ажиллах журам”-ын дагуу сангийн хөрөнгийг бүрдүүлж зарцуулан, гүйцэтгэлийг тайлагнаж, хяналт тавьж ажиллах талаар зөвлөмж хүргүүлэхээр шийдвэрлэсэн.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

### 4.5.1 Завсрын аудитын талаар

Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар сургуулийн 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд завсрын аудит хийгдээгүй болно.

### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны аудитаар цалингийн зардлын данстай холбоотой 2,922.4 мянган төгрөг, материалын зардлын данстай холбоотой 5,485.2 мянган төгрөгийн нийт 8,407.6 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн ба хэрэгжилийг шалгахад 100 хувь биелүүлсэн байна.

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Өмнөх аудитын үзүүлэлт | | Биелэлт | | |
|---|---|---|---|---|---|
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Хувь |
| Зөвлөмж | 5 | 1,881.6 | 5 | 1,881.6 | 100.0 |
| **Нийт дүн** | 5 | 1,881.6 | 5 | 1,881.6 | 100.0 |

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Боловсролын ерөнхий газрын даргын 2024 оны 01 дүгээр сарын 12-ны өдөр 1,175,325.4 мянган төгрөгийн төсвийн хуваарь батлагдаж ирсэн. Мөн 2024 оны 12 дугаар сарын 28-ны өдөр 132,277.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлж харилцах дансны үлдэгдэл өсөж төсвийн гүйцэтгэл 82.5 хувьтай гарсан байна. Иймд төсвийн төлөвлөлттэй холбоотой асуудлыг дараагийн шатны аудитаар шалгаж, шийдэл гаргах нь зүйтэй байна.

## 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 33,413.5 мянган төгрөгийн алдаа[1] илэрснээс аудитын явцад 30,450.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 750.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,213.5 мянган төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.Үүнд:

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

- Боловсролын яамны 2024.10.03-ны шийдвэрээр 15 ш зөөврийн компьютер үнэ төлбөргүй ирсэн 30,450,000.0 төгрөгийн Санхүүгийн тайланд тайлагнаагүй нь НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 9.1, 9.2 дахь хэсэг заасан заалттай нийцээгүй “Нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Аудитаар нийт 2,963.5 мянган төгрөгийн зөрчил[2] илэрснээс 750.0 мянган төгрөгийн төлбөрийн акт тогтоож, 2,213.5 мянган төгрөгийн зөвлөмж өгсөн.

**5.1 Төлбөрийн акт**

Тайлант онд Сургуулийн захирал Б.Цогзолмаа нь дээд газрын зөвшөөрөлгүй өөртэй тушаал шийдвэргүй илүү цагийн хөлс 2 удаа 23 цаг, нийт 750.0 мянган төгрөг авсан нь Засгийн газрын 2018 оны 382-р тогтоолын 2-р хавсралт" Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.9 дах заалтыг хэрэгжүүлээгүй нь “Нийцсэн бөгөөд зохистой байх” зэрэг батламж мэдэгдлийг хангахгүй байна.

**5.2 Албан шаардлага**

Аудитаар албан шаардлага хүргүүлэх зөрчилтэй асуудал илрээгүй болно

**5.3 Зөвлөмж**

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**5.3.1. Зардлын данстай холбоотой асуудал**

5.3.1.1 Илрүүлэлт:

Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 4 дүнгээр түвшинд үнэлэгдэж нэг удаагийн урамшуулал шагнал болох 21,386,600.0 төгрөг ажилтнуудад олгож НДШ 2,459,459.0 төгрөг суутгаагүй, илүү суутгасан ХХОАТ 245,946.0 төгрөг нийт 2,213,513.0 төгрөг ийн зөрчил нь Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3.ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал; Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна: 7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого; заалттай нийцэхгүй байна

5.3.1.2 Өгсөн зөвлөмж:

Хууль тогтоомжийн заалтуудыг хэрэгжүүлэх

Дээрх зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5[3]-д заасан хугацаанд ирүүлж, биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2025 оны 5 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү

---

[2] Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

[3] *Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.*

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үнэ төлбөргүй ирсэн хөрөнгийг санхүүгийн тайланд тусгаагүй | 1 | 30450.0 | | | 1 | 30450.0 | 1 | 30450.0 | | | | |
| Дүн | 1 | 30450.0 | | | 1 | 30450.0 | 1 | 30450.0 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Цалингийн зардлын данстай холбоотой асуудал | 1 | 750.0 | 1 | 750,0 | | | | - | | | | |
| Зардлын данстай холбоотой асуудал | 1 | 2,213.5 | | | | | 1 | 2,213.5 | | | | |
| Дүн | 2 | 2963.5 | 1 | 750.0 | | | 1 | 2,213.5 | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| Тайлант онд батлагдсан төсвөөс ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй байна. | 1 | | | | | | 1 | |
| Дүн | 1 | | | | | | 1 | |

МУЕА-ын 2021 оны 6 дугаар сарын 18 -ны
өдрийн А/70 дугаар тушаалын хавсралт 2

Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар сургууль

**ААБ 5.5: АСУУДЛЫН БҮРТГЭЛ**

Тайлант хугацаа: 2024 он

*Хүснэгт А. АГАДҮТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх*

/төгрөгөөр/

| № | Нөлөөлж буй АГАДҮТ | АГАДҮ Т-ийн дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөж тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт | | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Стандартын заалт | Хууль тогтоомжийн заалт | | | | | |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | Ажил гүйлгээний анги | Цалингийн зардлын данстай холбоотой асуудал | Сургуулийн захирал Б.Цогзолмаа нь дээд газрын зөвшөөрөлгүй өөртэй тушаал шийдвэргүй илүү цагийн хөлс 2 удаа 23 цаг, нийт 750,000.0 төгрөг авсан байна. | 750,000.00 | Тийм | тийм | УСНББОУС-1 | Засгийн газрын 2018 оны 382-р тогтоолын 2-р хавсралт" Төрийн захиргааны болон үйлчилгээний албан хаагчид нэмэгдэл хөлс олгох журмын 3.1 дэх заалт, Төсвийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2, 5.1.5 дахь заалт, 6 дугаар зүйлийн 6.6.2 дахь заалт, 16 дугаар зүйлийн 16.5.9 дах заалттай нийцэхгүй байна. | Хууль тогтоом жийн хэрэгжилт тэй холбоотой | Төлбөрийн акт тогтоох | | | |
| 7 | Ажил гүйлгээний анги | Зардлын данстай холбоотой асуудал | Байгууллагын гүйцэтгэлийн үнэлгээгээр 4 дүнгээр түвшинд үнэлгдэж нэг удаагийн урамшуулал шагнал болох 21,386,600.0 төгрөг ажилтнуудад олгож НДШ 2,459,459.0 төгрөг суутгаагүй, илүү суутгасан ХХОАТ 245,946.0 төгрөг нийт 2,213,513.0 төгрөг байна | 2,213,513.0 | Үгүй | Үгүй | УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга | Нийгмийн даатгалын ерөнхий хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.3.ажил олгогчоос даатгуулагчид мөнгөн хэлбэрээр олгосон хоол, унаа, түлээ, нүүрсний үнийн хөнгөлөлт, орон сууцны ашиглалтын төлбөр, тэдгээртэй адилтгах бусад орлого, сар, улирал, жилийн ажлын үр дүнг харгалзан олгосон шагнал, урамшуулал; Хувь хүний орлогын албан татварын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.Албан татвар төлөгчийн цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод дараах орлогыг хамруулна: 7.1.1.ажил олгогчтой байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасны дагуу авч байгаа үндсэн цалин, нэмэгдэл хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал, амралтын олговор, тэтгэвэр, тэтгэмж, тэдгээртэй адилтгах бусад орлого; | Хууль тогтоом жийн хэрэгжилт тэй холбоотой | Зөвлөмж өгөх | | | |
| | | | Дүн | 2,963,513.00 | | | | | | | | | |

*Хүснэгт Б. Санхүүгийн тайлангийн түвшинд болон ач холбогдолтой биш АГАДҮТ-ыг үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх*

| № | Тодорхойлсон эрсдэл | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөж тооцох эсэх | Шалгуур үзүүлэлт | | Алдаа зөрчлийн ангилал | ...байгууллагаас гаргасан | ...лагын санал, тайлбар | ...лагаас өгсөн | шийдэ... |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Стандартын заалт | Хууль тогтоомжийн заалт | | | | | |
| 1 | Санхүүгийн тайланг УСНББОУС болон Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд заасан шаардлагууд болон Сангийн яамнаас гаргасан заавар журмын дагуу иж бүрэн бэлтгээгүй байх | Боловсролын яамны 2024.10.03-ны шийдвэрээр 15 ш зөөврийн компьютер үнэ төлбөргүй ирсэн 30,450,000.0 төгрөгийн Санхүүгийн тайланд тайлагнаагүй тул залруулга хийсэн | 30,450,000.00 | Материаллаг | Тийм | УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга | НББ-ийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1, 20 дугаар зүйлийн 20.2.3, Сангийн сайдын 2025 оны А/3 дугаар тушаалаар баталсан "Төсвийн байгууллагын дагаж мөрдөх нягтлан бодох бүртгэлийн журам"-ын 9.1, 9.2 дахь хэсэг | Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой | Санхүүгийн тайланд залруулах | | | |
| 2 | | Тайлант онд батлагдсан төсвөөс ахмадын сан байгуулж, хөрөнгө мөнгө төвлөрүүлээгүй байна. | - | Тийм | Үгүй | УСНББОУС-1 Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга | Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн14.7-д "Энэ хуулийн 14.6-д заасан арга хэмжээнд зориулан аж ахуйн нэгж, байгууллага өөрийн төсөв, үйл ажиллагааны орлогоосоо төсвийн байгууллага тухайн жилийн төсөвт тусган цалингийн нийт сангийн гурав хүртэл хувьтай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгөөр "Ахмадын сан" байгуулах", Засгийн газрын 2017 оны 197 дугаар тогтоолоор баталсан "Ахмадын сан байгуулан ажиллах журам"-ын 1.1, 1.2, 1.3, 2.1.1 дэх заалтуудтай нийцэхгүй байна. | Хууль тогтоомжийн заалттай холбоотой асуудал. | Зөвлөмж | | | |
| Дүн | | | 30,450,000.0 | | | | | | | | | |

**Бэлтгэсэн:**
Аудитор Б.Хоролбат
огноо:

**Хянасан:**
Чанарын хяналтын менежер Л.Магсаржалам
Огноо:

Шинжлэн магадлахуй ЗЗШ аудит ХХК-ийн захирал С.Оргил
Огноо:

**Танилцаж, зөвшөөрсөн**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар сургууль

Дарга Б.Цэрэнлхам Огноо:

Нягтлан бодогч Б.Одсайхан Огноо:

9022368 1924100003 ОТ0049

МУЕА-ын 2021
сарын 18 -ны өдр
тушаалын ха

## ААБ 5.5: АСУУДЛЫН БҮРТГЭЛ

Байгууллагын нэр: Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар сургууль
Тайлант хугацаа: 2024 он
Хүснэгт А. АГАДҮТ-ын үнэлсэн алдаа, зөрчлийг шийдвэрлэх

/мянган төгрөгөөр/

| № | Ажил гүйлгээний анги, дансны үлдэгдэл, тодруулга | АГАДҮТ-ийн дэд анги | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Материаллаг эсэх | Үр өгөөж тооцох эсэх | Хууль тогтоомжийн заалт | Алдаа зөрчлийн ангилал | Аудитын байгууллагаас гаргасан шийдэл | Байгууллагын санал, тайлбар | Аудитын байгууллагаас өгсөн хариу | Гаргасан шийдэл |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 8 | 9 | 10 | 11 | 12 | 13 |
| 1 | Балансын данстай холбоотой асуудал | Шилэн данс | Шилэн дансны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан хэрэгжилт 99.9 хувьтай ба 6.1.1 Тухайн жилийн байгууллагын батлагдсан төсөв хугацаа хоцорч мэдээлсэн байна. | | Үгүй | Үгүй | Шилэн дансны тухай хуулийн 6.1. "Энэ хуулийн 3.1.1-т заасан байгууллага дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ." 6.1.1. "Тухайн жилийн төсвийг жил бүрийн 1 дүгээр сарын 10-ны өдрийн дотор мэдээллэх" гэсэн заалтуудтай нийцэхгүй эрх ба үүрэг батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна | Шилэн дансны тайлагналтай холбоотой | Зөвлөмж | | | |
| **Дүн** | | | | - | | | | | | | | |

**Бэлтгэсэн:**
Аудитор — Б.Хоролбат
Огноо:

**Хянасан:**

Чанарын хяналтын менежер — Л.Магсаржалам
Огноо:

Шинжлэн магадлахуй ЗЗШ аудит ХХК-ийн захирал — С.Оргил
Огноо:

**Танилцаж, зөвшөөрсөн**

Дархан-Уул аймгийн Дархан сумын 12 дугаар сургууль

Дарга — Б.Цогзолмаа
Огноо:

Нягтлан бодогч — Б.Одсайхан
Огноо:

9022368 1924100003 ОТ0049